ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/421
танай ____________-ны №____________-т

БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Боловсролын мэдээллийн технологийн төвд цахим сургалтын хэлтсийг байгуулж, 320 багштай гэрээ байгуулан 17,000 орчим ахлах ангийн сурагчдад сонгон судлах хичээлийг зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр, боловсролын яамны хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн санхүүжилтээр bagsh.edu.mn серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 415,800.0 мянган төгрөгийн 2 ширхэг сервер, Боловсролын сайдын 2025 оны 10 дугаар сарын 14-



1520140855

ний өдрийн А/492 дугаар тушаалаар Боловсролын салбарын Дата төвийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, найдвартай ажиллагааг хангах техник, технологийн орчныг бүрдүүлэх зорилгоор 3,181,959.6 мянган төгрөгийн 26 ширхэг сүлжээний тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэж, хүлээлгэн өгсөн байна.

**Бусад асуудал**

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Тус төв нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:САГ-2026/42/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
Утас:51-261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: С.Нацагдорж**
Утас:260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
**Аудитор: Б.Батхишиг**
Утас:261628 Цахим хаяг: batkhishigb@audit.gov.mn
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн Ихмонгол хөлөг аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг**
Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn



Улаанбаатар хот
2026 он

## АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 12
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 16
3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 17
3.5.3 Нэмэлт төсөв ..... 18
3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ..... 18
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ..... 19
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 20
4.1 Ерөнхий зүйл ..... 20
4.2 Материаллаг байдал ..... 20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 21
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 22
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 23
5.1 Албан шаардлага ..... 23
5.2 Зөвлөмж ..... 24
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 26

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УТҮГ | Улсын төсөвт үйлдвэрийн газар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/421
танай ____________-ны №____________-т

БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заах дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Боловсролын мэдээллийн технологийн төвд цахим сургалтын хэлтсийг байгуулж, 320 багштай гэрээ байгуулан 17,000 орчим ахлах ангийн сурагчдад сонгон судлах хичээлийг зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр, боловсролын яамны хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн санхүүжилтээр bagsh.edu.mn серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 415,800.0 мянган төгрөгийн 2 ширхэг сервер, Боловсролын сайдын 2025 оны 10 дугаар сарын 14-

ний өдрийн А/492 дугаар тушаалаар Боловсролын салбарын Дата төвийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, найдвартай ажиллагааг хангах техник, технологийн орчныг бүрдүүлэх зорилгоор 3,181,959.6 мянган төгрөгийн 26 ширхэг сүлжээний тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэж, хүлээлгэн өгсөн байна.

**Бусад асуудал**

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Тус төв нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-103.Docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **133,144,514.11** | **212,082,047.51** |
| **33** | **АВЛАГА** | **33,528.10** | **86,204,273.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 33,528.10 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 85,672,053.00 |
| 33500 | Бусад авлага | - | 532,220.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 532,220.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **133,110,986.01** | **125,877,774.51** |
| 35400 | Хангамжийн материал | 133,110,986.01 | 125,877,774.51 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,565,850.01 | 3,186,950.01 |
| 35420 | Аж ахуйн материал | 576,020.00 | 263,220.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 42,273,127.00 | 35,364,529.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,390,000.00 | 1,720,103.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 85,305,989.00 | 85,342,972.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,525,728,966.76** | **8,479,159,156.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **6,525,728,966.76** | **8,479,159,156.83** |
| 39200 | Биет хөрөнгө | 4,522,969,556.00 | 7,006,348,450.46 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 4,369,850,984.71 | 8,087,390,584.71 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,025,799,591.34) | (2,250,616,661.88) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 55,393,291.28 | 55,393,291.28 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (15,275,128.65) | (24,618,763.65) |
| 39217 | Ном | 1,138,800,000.00 | 1,138,800,000.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 2,002,759,410.76 | 1,472,810,706.37 |
| 39301 | Программ хангамж | 3,025,841,849.84 | 3,025,841,849.84 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,023,791,940.04) | (1,553,207,144.75) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,270,000.00 | 1,270,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (560,499.04) | (1,093,998.72) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,658,873,480.87** | **8,691,241,204.34** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **610,273,492.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **610,273,492.00** |
| 41300 | Өглөг | - | 610,273,492.00 |
| 41360 | Бусад өглөг | - | 610,273,492.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 609,741,272.00 |
| 41364 | НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | - | 532,220.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,658,873,480.87** | **8,080,967,712.34** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **6,658,873,480.87** | **8,080,967,712.34** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 142,200,008.65 | 142,200,008.65 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 142,200,008.65 | 142,200,008.65 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 6,516,673,472.22 | 7,938,767,703.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 5,654,954,456.62 | 6,516,673,472.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 861,719,015.60 | 1,422,094,231.47 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,658,873,480.87** | **8,691,241,204.34** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **15,332,960,979.05** | **13,447,241,852.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,376,129,171.05** | **13,447,241,852.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,376,129,171.05** | **3,600,986,812.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,100,000.00 | 3,200,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,100,000.00 | 3,200,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,363,065,671.05 | 3,597,759,600.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 9,963,500.00 | 27,212.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **9,846,255,040.00** |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 9,846,255,040.00 |
| 12211 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 9,467,217,700.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 9,467,217,700.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 379,037,340.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 379,037,340.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **12,956,831,808.00** | **-** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 12,663,608,000.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 12,663,608,000.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 293,223,808.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 54,835,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 238,388,808.00 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **13,911,631,623.76** | **12,025,147,620.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **13,911,631,623.76** | **12,025,147,620.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **13,867,338,841.97** | **11,761,219,192.70** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,000,452,856.44 | 3,091,629,159.11 |
| 210101 | Үндсэн цалин | 1,648,129,176.99 | 2,680,181,737.01 |
| 210102 | Нэмэгдэл | 255,667,679.45 | 287,453,722.10 |
| 210104 | Урамшуулал | 96,656,000.00 | 123,993,700.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 245,873,449.18 | 328,830,277.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 168,923,587.84 | 229,631,567.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 18,959,783.09 | 24,008,843.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 9,361,091.52 | 11,849,321.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 10,090,947.91 | 11,009,986.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 38,538,038.82 | 52,330,557.08 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 260,366,750.00 | 341,072,328.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,211,750.00 | 10,853,600.00 |
| 210304 | Байрны түрээс | 250,155,000.00 | 330,218,728.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 32,842,330.68 | 12,887,309.56 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,246,766.00 | 4,592,589.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,012,357.50 | 2,524,949.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,183,954.18 | 1,755,971.56 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.00 | 1,080,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,691,654.00 | 2,933,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 9,707,599.00 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | 47,839,280.00 | 48,561,361.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 47,839,280.00 | 48,561,361.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,929,489,320.96 | 5,797,723,853.11 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
БАТАЛГААЖУУЛСАН

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,926,608,120.96 | 5,515,734,263.11 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,616,200.00 | 3,383,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,265,000.00 | 278,605,790.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,350,474,854.71 | 2,140,514,904.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 776,643,314.99 | 367,435,494.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 8,970,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,573,831,539.72 | 1,764,109,409.93 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **44,292,781.79** | **263,928,427.83** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 263,928,427.83 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 263,928,427.83 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 263,928,427.83 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 263,928,427.83 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,500,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,500,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 41,792,781.79 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,787,763.79 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,018.00 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,421,329,355.29** | **1,422,094,231.47** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **559,610,339.69** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 559,610,339.69 | - |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **(559,610,339.69)** | **-** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **861,719,015.60** | **1,422,094,231.47** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **12,959,931,808.00** | **9,860,655,040.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,100,000.00** | **9,860,655,040.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,100,000.00** | **14,400,000.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,100,000.00 | 3,200,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,100,000.00 | 3,200,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 11,200,000.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **9,846,255,040.00** |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 9,846,255,040.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 9,467,217,700.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 9,467,217,700.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 379,037,340.00 |
| 122131 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 379,037,340.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **12,956,831,808.00** | **-** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 12,663,608,000.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 12,663,608,000.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 293,223,808.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 54,835,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 238,388,808.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,291,679,988.00** | **9,740,875,040.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,291,679,988.00** | **9,740,875,040.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,247,387,206.21** | **9,391,274,559.17** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,974,096,305.99 | 3,061,684,068.01 |
| 210101 | Үндсэн цалин | 1,622,947,901.76 | 2,638,194,931.27 |
| 210102 | Нэмэгдэл | 254,993,224.23 | 282,112,936.74 |
| 210104 | Урамшуулал | 96,155,180.00 | 141,376,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 246,868,000.00 | 358,741,840.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 167,870,300.00 | 261,755,157.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 19,749,400.00 | 23,456,837.06 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 9,874,700.00 | 11,573,318.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 9,874,700.00 | 10,733,983.59 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 39,498,900.00 | 51,222,543.76 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 260,266,110.00 | 341,072,328.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,111,110.00 | 10,853,600.00 |
| 210304 | Байрны түрээс | 250,155,000.00 | 330,218,728.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,857,500.18 | 9,959,861.56 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,699,900.00 | 2,074,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,306,725.00 | 2,827,840.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,183,954.18 | 1,755,971.56 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.00 | 1,080,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,666,921.00 | 2,222,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,000,000.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,000,000.00 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | 47,839,280.00 | 48,640,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 47,839,280.00 | 48,640,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,946,045,363.05 | 5,203,674,281.11 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,943,164,163.05 | 4,921,684,691.11 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,616,200.00 | 3,383,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,265,000.00 | 278,605,790.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 744,414,646.99 | 367,502,180.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 744,414,646.99 | 358,054,180.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 9,448,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **44,292,781.79** | **349,600,480.83** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 349,600,480.83 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 349,600,480.83 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 349,600,480.83 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 263,928,427.83 |
| 2131125 | Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 11,200,000.00 |
| 2131126 | Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 74,472,053.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,500,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,500,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 41,792,781.79 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,787,763.79 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,018.00 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **668,251,820.00** | **119,780,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **668,251,820.00** | **119,780,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **668,251,820.00** | **119,780,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 668,251,820.00 | 119,780,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 668,251,820.00 | 119,780,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(668,251,820.00)** | **(119,780,000.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-** | **-** |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **142,200,008.65** | **5,654,954,456.62** | **5,797,154,465.27** |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 142,200,008.65 | 5,654,954,456.62 | 5,797,154,465.27 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | 861,719,015.60 | 861,719,015.60 |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **142,200,008.65** | **6,516,673,472.22** | **6,658,873,480.87** |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 142,200,008.65 | 6,516,673,472.22 | 6,658,873,480.87 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | 1,422,094,231.47 | 1,422,094,231.47 |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **142,200,008.65** | **7,938,767,703.69** | **8,080,967,712.34** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **10,254,762,200.00** | **9,206,489,272.17** | **1,048,272,927.83** | **89.8** |
| **12** | **Татварын бус орлого** | **10,254,762,200.00** | **9,206,489,272.17** | **1,048,272,927.83** | **89.8** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **4,000,000.00** | **3,200,000.00** | **800,000.00** | **80.0** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 4,000,000.00 | 3,200,000.00 | 800,000.00 | 80.0 |
| **122** | **Тусламжийн орлого** | **10,250,762,200.00** | **9,203,289,272.17** | **1,047,472,927.83** | **89.8** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 10,250,762,200.00 | 9,203,289,272.17 | 1,047,472,927.83 | 89.8 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,254,762,200.00** | **9,206,489,272.17** | **1,048,272,927.83** | **89.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,254,762,200.00** | **9,206,489,272.17** | **1,048,272,927.83** | **89.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **10,254,762,200.00** | **9,206,489,272.17** | **1,048,272,927.83** | **89.8** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,096,569,700.00 | 3,061,684,068.01 | 34,885,631.99 | 98.9 |
| 210101 | Үндсэн цалин | 2,847,602,400.00 | 2,638,194,931.27 | 209,407,468.73 | 92.6 |
| 210102 | Нэмэгдэл | 167,967,400.00 | 282,112,936.74 | (114,145,536.74) | 168.0 |
| 210104 | Урамшуулал | 80,999,900.00 | 141,376,200.00 | (60,376,300.00) | 174.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 386,484,400.00 | 358,741,840.49 | 27,742,559.51 | 92.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 263,014,700.00 | 261,755,157.50 | 1,259,542.50 | 99.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 30,826,500.00 | 23,456,837.06 | 7,369,662.94 | 76.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,407,000.00 | 11,573,318.58 | 3,833,681.42 | 75.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,385,600.00 | 10,733,983.59 | 4,651,616.41 | 69.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 61,850,600.00 | 51,222,543.76 | 10,628,056.24 | 82.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 390,467,200.00 | 341,072,328.00 | 49,394,872.00 | 87.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,051,100.00 | 10,853,600.00 | 2,197,500.00 | 83.2 |
| 210304 | Байрны түрээс | 377,416,100.00 | 330,218,728.00 | 47,197,372.00 | 87.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,477,600.00 | 9,132,021.56 | 7,345,578.44 | 55.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,994,300.00 | 2,074,050.00 | 920,250.00 | 69.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,229,100.00 | 1,755,971.56 | 1,473,128.44 | 54.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,080,000.00 | 1,080,000.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,174,200.00 | 2,222,000.00 | 4,952,200.00 | 31.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,954,448,900.00 | 5,068,356,834.11 | 886,092,065.89 | 85.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,511,792,500.00 | 4,766,467,244.11 | 745,325,255.89 | 86.5 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 3,383,800.00 | 1,616,200.00 | 67.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 437,656,400.00 | 298,505,790.00 | 139,150,610.00 | 68.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 410,314,400.00 | 367,502,180.00 | 42,812,220.00 | 89.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 396,351,000.00 | 358,054,180.00 | 38,296,820.00 | 90.3 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,963,400.00 | 9,448,000.00 | 4,515,400.00 | 67.7 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **80** | **65** | **15** | **81.3** |
| 620001 | Удирдах ажилтан | 7 | 7 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 73 | 59 | 14 | 80.8 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **80** | **65** | **15** | **81.3** |
| 650013 | Шатлалгүй цалин | 80 | 65 | 15 | 81.3 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **-** | **379,037,340.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **379,037,340.00** |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **379,037,340.00** |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 379,037,340.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 379,037,340.00 |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 379,037,340.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **304,565,287.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **304,565,287.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **304,565,287.00** |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 827,840.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 827,840.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 48,640,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 48,640,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 255,097,447.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 255,097,447.00 |
| **4** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-** | **74,472,053.00** |
| **5** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **(74,472,053.00)** |
| **6** | **Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт** | **-** | **(74,472,053.00)** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын мэдээллийн технологийн төв үндсэн зорилгоо “Боловсролын салбарын мэдээллийн болон удирдлагын систем, сургалтын цахим контент, сургалтын нэгдсэн платформ, мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ болон боловсролын дата төвийн тогтвортой ажиллагааг хангах, хяналтыг хэрэгжүүлэх, боловсролын салбарт шинэ технологийг судлах, инновацыг нэвтрүүлэх, турших, түгээн дэлгэрүүлэх, цахим сургалт зохион байгуулах, их өгөгдлийг ашиглах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Боловсролын мэдээллийн технологийн төв нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Боловсролын салбарын мэдээллийн систем болон түүний программ хангамжийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглалт хэрэглээг дэмжих, тогтвортой ажиллагааг хангах;
- Сургалтын цахим контент удирдлагын систем болон түүний программ хангамжийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглалт хэрэглээг дэмжих, тогтвортой ажиллагааг хангах;
- Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг хянах, түүний тогтвортой үйл ажиллагааг хангах, дэд бүтцийн өргөтгөл хийх;
- Боловсролын дата төвийн тогтвортой үйл ажиллагааг хангах, дэд бүтцийн өргөтгөл хийх;
- Боловсролын салбарын мэдээллийн сангийн хөгжүүлэлт, тогтвортой ажиллагаа болон түүний зохицуулалтыг хариуцах;
- Боловсролын салбарын байгууллагуудад мэдээллийн технологи болон интернэтийн үйлчилгээ үзүүлэх;
- Мэдээллийн технологийн зөвлөх, сургалтын үйлчилгээ үзүүлэх;
- Систем, сан, сүлжээг төрийн болон холбогдох байгууллагын мэдээллийн системтэй уялдуулах, тэдгээртэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх, нууцлал, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, сайжруулах, техник, технологи, инновацын судалгаа хийх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Олон улсын боловсрол, шинжлэх ухааны мэдээллийн сүлжээнд холбогдох, салбарт нэвтрүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангах;
- Цахим сургалт зохион байгуулах, бүх түвшний боловсролын цахим сургалтад дэмжлэг үзүүлэх;
- Боловсролын салбарт нэвтрүүлэх шинэ технологийг судлах, турших, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах;
- Боловсролын их өгөгдлийн сан бүрдүүлэх, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.6 гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсролын мэдээллийн технологийн төв нь боловсролын салбарын мэдээллийн технологийн хэрэгжүүлэлт, систем, нэгдсэн сүлжээний хяналт, хөгжлийн асуудлыг

хариуцан ажиллах чиг үүрэгтэй, Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Боловсролын мэдээллийн технологийн төв нь Боловсролын ерөнхий хууль, Харилцаа холбооны тухай хууль, Инновацын тухай хууль, Хувь хүний нууцын тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 5 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;
- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай журам шинэчлэн батлагдсан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Боловсрол шинжлэх ухааны  сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/10 тушаалаар шинэчлэн баталсан Боловсролын мэдээллийн технологийн төвийн бүтэц орон тооны дээд хязгаарт дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтны орон тоог батлаагүй, дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтангүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах  шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд чиглэнэ.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төв нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг бөгөөд уг баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн боловч, санхүүжилт, дотоод хяналт, үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй, ерөнхий байдлаар боловсруулсан шинээр батлагдан гарч буй стандарт, хууль тогтоомж, заавар, журамтай нийцүүлэн шинэчлэлт өөрчлөлт хийгдээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.
Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.
Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,032,367.7 мянган төгрөгөөр буюу 30.5 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт***

***/мянган төгрөгөөр/***

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 33.5 | 86,204.3 | 86,170.8 |
| Бараа материал | 133,111.0 | 125,877.7 | (7,233.3) |
| Үндсэн хөрөнгө | 6,525,729.0 | 8,479,159.1 | 1,953,430.1 |
| **Нийт хөрөнгө** | **6,658,873.5** | **8,691,241.1** | **2,032,367.6** |
| Өр төлбөр | - | 610,273.4 | 610,273.4 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 142,200.0 | 142,200.0 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 6,516,673.5 | 7,938,767.7 | 1,422,094.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **6,658,873.5** | **8,691,241.1** | **2,032,367.6** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл нь 86,204.3 мянган төгрөг болж 86,170.8 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүмүүсээс авах авлага 498.7 мянган төгрөгөөр өссөн, нэр данс зөрүүтэй 11,200.0 мянган төгрөг, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн банкны санхүүжилтийн зарцуулагдаагүй 74,472.0 мянган төгрөгийн төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэнтэй холбоотой.
- Бараа материалын дансны үлдэгдэл нь өмнөх оноос 7,233.3 мянган төгрөгөөр буурсан нь 11,151.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 18,384.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 1,953,430.1 мянган төгрөгөөр өссөн бөгөөд тайлант хугацаанд дараах хөдөлгөөн өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 119,780.0 мянган төгрөгийн 2 нэр төрлийн интернэтийн тоног төхөөрөмжийг худалдан авч, Боловсролын яамны Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-ийн санхүүжилтээр bagsh.edu.mn серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай 415,800.0 мянган төгрөгийн 2 ширхэг сервер, Боловсролын сайдын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/492 дугаар тушаалаар "Боловсролын салбарын Дата төвийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 3,181,959.5 мянган төгрөгийн 26 ширхэг сүлжээний тоног төхөөрөмжийг хөрөнгө оруулалтаар хүлээлгэн өгснийг тус тус орлогод авсан;
- Тайлант хугацаанд 1,764,109.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэрэг нь нөлөөлсөн.

- Өр төлбөр дансны үлдэгдэл 610,273.4 мянган төгрөгөөр өссөн нь Юнивишн компанид 11,200.0 мянган төгрөгийг интернэтийн төлбөрт шилжүүлсэн боловч нэр данс зөрүүтэй шалтгаанаар төлөгдөөгүй, Мэдээлэл холбооны сүлжээ компанид төлөх сувагчлал, байр ашиглалт, засвар үйлчилгээ, орон нутгийн тоон сувгийн 598,541.3 мянган төгрөгийн гэрээний төлбөрийг, санхүүжилтийн эх үүсвэргүйгээс барагдуулаагүй нь нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 1,422,094.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 82,289,156.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 4,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 82,293,156.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас, дотоод албан томилолтын зардлыг 10,530.0 мянган төгрөгөөр, 1 удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 14,300.0 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 30,690.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,003,903.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 50,432,071.5 мянган төгрөгөөр, нийт 56,491,494.9 мянган төгрөгөөр бууруулж, хангамжийн материалын зардлыг 7,440.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 349,443.2 мянган төгрөгөөр, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,746,425.5 мянган төгрөгөөр, нийт 2,103,308.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 27,904,970.6 мянган төгрөгөөр хянан баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 17,649,508.4 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг

санхүүжүүлэхээр 10,254,762.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 9,467,217.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 3,200.0 мянган төгрөгийг орлого төвлөрүүлж, 9,206,489.3 мянган төгрөгийг зарцуулж, 263,928.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,206,489.3 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардал 7,345.5 мянган төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 34,885.6 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардал 42,812.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 49,394.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж 745,325.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

***/мянган төгрөгөөр/***

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71809-80101- Үндсэн үйл ажиллагааны зардал | 4,350,618.7 | 4,081,967.8 | 268,650.9 | 93.8 |
| 2 | 71809-80220-Холбооны суваг ашигласны хөлс | 2,570,746.4 | 1,827,481.9 | 743,264.5 | 71.1 |
| 3 | 71809-81569-Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 3,798.5 | 1,738.0 | 2,060.5 | 45.8 |
| 4 | 71809-81834- Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэмжээ | 3,333,598.6 | 3,295,301.5 | 38,297.0 | 98.9 |
| | **ДҮН** | **10,258,762.2** | **9,206,489.2** | **1,052,272.9** | **89.8** |

**Судалгааны үр дүн**: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгаа авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/10 дугаар тушаалаар 80 орон тоотой ажиллахаар дээд хязгаарыг тогтоосноос гүйцэтгэлээр удирдах 7, гүйцэтгэх 59, нийт 65 орон тоотойгоор ажилласан байна.
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд унаа хоолны хөнгөлөлт олгохоор заагаагүй байна.
- Гадаад томилолт, арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй, тайлант онд санхүүжүүлээгүй байна.
- Тайлант онд дотоодын 2, гадаад улсад зохион байгуулах 1 сургалтад 3 ажилтан оролцуулахаар 4,027.4 мянган төгрөгийг 2025 оны төсөвт тусгаж, гүйцэтгэлээр 100 хувийн зарцуулалттай байна.
- Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулаагүй байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангаас сурагчийн эрүүл мэндийн картыг цахимжуулах, олон нийтийн харилцах мэдээллийн ажилтан сургагч багш бэлтгэх төслийг хэрэгжүүлэхэд 304,567.8 мянган төгрөг, Дэлхийн банкнаас хиймэл оюун ухаанд багшийн туслах бэлтгэх төслийн урьдчилгаанд 74,469.5 мянган төгрөг, нийт 379,037.3 мянган төгрөгийн санхүүжилт бүрдсэнээс тээвэр, шатахуунд 827.8 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 48,640.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 255,097.4 мянган төгрөг, нийт 304,565.3 мянган төгрөгийг зарцуулж, 74,472.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

***Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт***

***/мянган төгрөгөөр/***

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц (хувь) | Төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сурагчийн эрүүл мэндийн картыг цахимжуулах төсөл | 2025-2026 | esis.edu системд үзлэгт хамрагдсан мэдээлэл байршсан байх | 60.0 | 129,000.0 | 56,421.4 |
| 2 | Олон нийттэй харилцах мэдээллийн ажилтан , сургагч багш бэлтгэх төсөл | 2025 | Боловсролын газрын 10 мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн 70 багшийг ОНЦМА бэлтгэх сургалтад хамруулж, батламж олгосон. | 100.0 | 175,567.8 | 175,567.8 |
| 3 | Хиймэл оюун ухаанд багшийн туслах бэлтгэх төсөл | 2025-2026 | Одоогоор 110 орчим багш хянах, боловсруулах чиг үүрэгтэй оролцсон байгаа бөгөөд нийт 14,947 асуулт хариулт ирүүлснээс нь одоогоор 12,322 асуулт, хариулт хянагдаж бэлэн болсон байна | 60.0 | 74,469.5 | 72,576.0 |
| **НИЙТ ДҮН** | | | | | **379,037.3** | **304,565.3** |

**Тайлбар тодруулга:** Нэгдсэн үндэсний байгууллагын төслөөр сурагчийн эрүүл мэндийн картыг цахимжуулах, олон нийтийн харилцах мэдээллийн ажилтан сургагч багш бэлтгэх төсөл, Дэлхийн банкны төслөөр хиймэл оюун ухаанд багшийн туслах бэлтгэх төсөл хэрэгжиж эхэлсэн. Дэлхийн банкны төслөөр 2025-2026 онд хэрэгжүүлэхээр нийт 35.0 мянган доллар буюу 122,500.0 мянган төгрөгийн санхүүжилтээр хиймэл оюун ухаанд багшийн туслах бэлтгэх төслийг хэрэгжүүлж тайлант онд 60.0 хувийн санхүүжилтийг авсан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 3,592,502.7 мянган төгрөгийн 10 ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 100,000.00 мянган төгрөгийн 1 ажлыг харьцуулалтын аргаар, нийт 11 төрлийн бараа, үйлчилгээг 3,692,502,7 мянган төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр www.tender.gov.mn цахим системээр 664,181.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар, 240,075.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 бараа, ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 2,358,679.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, нийт 3,262,935.8 мянган төгрөгийн 9 бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан 9 гүйцэтгэгчтэй 3,262,935.8 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 2,673,346.4 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Боловсролын мэдээллийн технологийн төв, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ихмонгол хөлөг аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Ш.Солонго, О.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, захирал С.Тунгалаг, Чанарын хяналтын менежер С.Сожидмаа нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Батхишиг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын мэдээлэл технологийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн 27,273,880.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 272,738.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 157 мэдээлэл байршуулахаас байгууллагын батлагдсан төсвийн мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:
Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж үзсэн.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, авлага, зардлын данснуудад горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар илэрсэн 1,134,514.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

- Шалгагдагч байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгөнд хяналтын түүвэрчилсэн тооллого гүйцэтгэхэд эд хариуцагч бүрээр хөрөнгийн карт хөтлөөгүй, хөрөнгийн кодолж бүртгээгүй;
- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт БМ-5 дугаар маягтыг хөтлөөгүй;

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 6,375.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж хүргүүлснийг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

***Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт***

***/мянган төгрөгөөр/***

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 6,375.0 | 1 | 6,375.0 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | 100.0 |
| **Нийт дүн** | **2** | **6,375.0** | **2** | **6,375.0** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн стандарт, Сангийн сайдын шинэчлэн баталсан заавар журмуудад нийцүүлэн шинэчлэн баталсан байдал, үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлсэн эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 72,578.5 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад 72,578.5 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

***Залруулсан алдаа:***

- Санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан цалин, хөдөлмөрийн хөлсийг татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнтэй тулган шалгахад НДШ-ийн тайланд 72,578.5 мянган төгрөгийг дутуу тайлагнасан;
- Шалгагдагч байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын А/3 дугаар тушаалаар баталсан маягт, аргачлалын дагуу иж бүрэн бэлтгээгүй зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 34,656.4 мянган төгрөгийн 4 зөрчил[2] илэрсэнд, 6,375.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 28,281.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 34,656.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 272,738.8 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

*1. Илрүүлэлт:* Цахимаар сургалт явуулдаг багш нарын контентын төлбөрт шилжүүлсэн гэх 6,375.0 мянган төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 “Анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Анхан шатны баримтын бүрдэлгүй, зориулалт тодорхойгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

*2. Илрүүлэлт:* Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах интернэт үйлчилгээний нэмэлт гэрээг төсөвт өртгийн 20 хувиас 28,281.4 мянган төгрөгөөр илүү дүнгээр Юнившн ХХК-тай шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12 "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", 36 дугаар зүйлийн 36.1.3 "Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол", 48 дугаар зүйлийн 48.7 "Захиалагч энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолын 1. "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нэмэлт гэрээ байгуулахдаа төсөвт өртгийн 20 хувиас хэтрүүлж худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэр төрлийн 60 ширхэг 80,752.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

**2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Сангийн сайдын батлагдсан заавар журмын дагуу нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж,

стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлалын "Хууль тогтоомж, зохицуулалт буюу бусад бүрэн эрх ДҮ 4.3 "...Нийтлэг зориулалттай санхүүгийн тайланг бэлтгэвэл зохих улсын секторын байгууллага ба хөтөлбөрийг хууль тогтоомж, зохицуулалт болон бусад бүрэн эрхэд тусгайлан заах буюу улс орон бүрийн холбогдох эрх бүхий байгууллагаас тодорхойлно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаж, өөрчлөлт, шинэчлэлт хийх саналыг бэлтгэж, дээд шатны төсөв захирагчид хүсэлт хүргүүлэх, шинэчлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан цалин, хөдөлмөрийн хөлсийг татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнтэй тулган шалгахад НДШ-ийн тайланд 72,578.5 мянган төгрөгийг дутуу тайлагнасан байна. | 1 | 72,578.5 | - | - | 1 | 72,578.5 | 1 | 72,578.5 | - | - | - | - |
| 2 | 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын А/03- аар тушаалаар баталсан маягт, аргачлалын дагуу иж бүрэн бэлтгээгүй байна. | 1 | - | - | - | 1 | - | 1 | - | - | - | - | - |
| | **Дүн** | **2** | **72,578.5** | **0** | **-** | **2** | **72,578.5** | **2** | **72,578.5** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Цахимаар сургалт явуулдаг багш нарын контентын төлбөрт шилжүүлсэн гэх 6,375.0 мянган төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. | 1 | 6,375.0 | - | - | 1 | 6,375.0 | - | - | - | - | - | - |
| 2 | Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэр төрлийн 60 ширхэг 80,752.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| 3 | Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах интернэт үйлчилгээний нэмэлт гэрээг төсөвт өртгийн 20 хувиас 28,281.4 мянган төгрөгөөр илүү дүнгээр Юнившн ХХК-тай шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. | 1 | 28,281.4 | - | - | 1 | 28,281.4 | - | - | - | - | - | - |
| 4 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Сангийн сайдын батлагдсан заавар журмын дагуу нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| | **Дүн** | **4** | **34,656.4** | **-** | **-** | **1** | **34,656.4** | **2** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | Шилэн дансны нэгдсэн системд 157 мэдээлэл байршуулахаас 1 мэдээлэл хугацаа хоцроосон байна. | 1 | - | - | - | 1 | - |
| | **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 509/А0150458 Улаанбаатар хот

САГ-2026/42/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсролын салбарт сургалтын зориулалтаар ашиглах интернэт үйлчилгээний нэмэлт гэрээг төсөвт өртгийн 20 хувиас 28,281,409.00 /Хорин найман сая хоёр зуун наян нэгэн мянга дөрвөн зуун есөн/ төгрөгөөр илүү дүнгээр Юнившн ХХК-тай шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12 "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", 36 дугаар зүйлийн 36.1.3 "Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол", 48 дугаар зүйлийн 48.7 "Захиалагч энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолын 1. "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

1. Нэмэлт гэрээ байгуулахдаа төсөвт өртгийн 20 хувиас хэтрүүлж шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын мэдээллийн технологийн төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Бат-Эрдэнэ/, нягтлан бодогч /Д.Наранцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ

ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — С.ТУНГАЛАГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 508/А0150458 Улаанбаатар хот

САГ-2026/42/ИА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахимаар сургалт явуулдаг багш нарын контентын төлбөрт шилжүүлсэн гэх 6,375,000.00 /Зургаан сая гурван зуун далан таван мянган/ төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 “Анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1 “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй, зориулалт тодорхойгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын мэдээллийн технологийн төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Бат-Эрдэнэ/, нягтлан бодогч /Д.Наранцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН<br>ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ<br>АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ<br>ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН<br>ЗАХИРАЛ С.ТУНГАЛАГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-88.Docx*

1526181059

ТЭМДЭГЛЭЛ

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг